







ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

ШУУРХАЙ УДИРДЛАГЫН НЭГЖИЙН ӨДӨР ТУТМЫН МЭДЭЭ

2017.06.02

АГУУЛГА


	<ul style="list-style-type: none">■ Шинэ тохиолдол бүртгэгдээгүй.
	<ul style="list-style-type: none">■ Хачигт халдварын 7 хоногийн мэдээ■ Галзуу өвчний 7 хоногийн мэдээ■ ДАЭМБ-ын мэдээ
	<ul style="list-style-type: none">■ Эрсдэлийн үеийн харилцаа холбоо<ul style="list-style-type: none">■ БНХАУ(H7N9)
	<ul style="list-style-type: none">■ Байхгүй

Дотоод албан хэрэгцээнд



ШИНЭЧЛЭГДСЭН МЭДЭЭ: ГАЛЗУУ, ХАЧИГТ ХАЛДВАР 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


ГАЛЗУУ ӨВЧНИЙ ЭРСДЭЛД ӨРТСӨН ТОХИОЛДОЛ, (ТОХ-97)



- 2017 оны 05-р сарын 29-ний өдөр Дундговь аймгийн Сайнцагаан сумаас галзуугийн эрсдэлд өртсөн 1 тохиолдол, 5-р сарын 31-ний өдөр Ховд аймгийн Мөнххайрхан сумаас 1 тохиолдол тус тус бүртгэгдсэн. 2017 онд тархвар судлалын тандалтын эхний 22 долоо хоногийн байдлаар галзуугийн эрсдэлд өртсөн 97 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 2.2 дахин их бүртгэгдсэн байна.



ХАЧИГТ ХАЛДВАРЫН СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛ N=870




Он гарсаар хачгаар дамжих халдварт өвчний нийт 870 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үе (335)-ээс 2.6 дахин өндөр үзүүлэлттэй байна. Тандалтын 22-р долоо хоногт 50 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх долоо хоногоос бодит тоогоор 77 тохиолдлоор бага бүртгэгдсэн байна.

Хачигт энцефалит өвчний нас барсан ТОХИОЛДЛЫН МЭДЭЭЛЭЛ:

Нас, хүйс	34 настай, эрэгтэй
Хөдөлмөр эрхлэлт	Малчин
Хачигт хазуулсан газар	Булган Хутаг-Өндөр сум Хантай баг
Хазуулсан огноо	Тодорхойгүй
Шинж тэмдэг илэрсэн огноо	2017.05.24
Эмнэлэгт үзүүлсэн/Эмнэлэгт хэвтсэн	2017.05.27 Хэвтсэн Булган НЭ
Анхны онош	Клещевой энцефалит энцефаломиелитическая форма тяжелая степень
Эмнэлзүйн шинж тэмгүүд	Гэнэт өндөр халуурах, толгой хүчтэй өвдөх, нүүр мөч саажсан, ухаан бүдэг, дагзны булчингийн хөшингө 2 хуруу, уналт таталт илэрсэн
Лабораторийн шинжилгээ	Ийлдэс судлалаар: Фермент холбоот эсрэг биеийн урвал (ELISA) Anti TBE Ig M эерэг, IgG сөрөг Нугасны усанд ПГУ TBE virus DNA илрээгүй
Тухайн өвчний эсрэг вакцин тариулсан эсэх	Үгүй
Нас барсан огноо/Ор хоног	2017.05.29 Ор хоног: 2 хоног
Эмчилгээ	А. Шалтгаан вирусын эсрэг, хачигт энцефалитийн ийлдэс. Б. Эмгэг жамын: антибиотик болон хүчилтөрөгч, зүрх судас дэмжих, хордлого тайлах, тайвшруулах, хаван хөөх гормон эмчилгээ.
Нас барсан эцсийн онош	Клещевой энцефалит энцефаломиелитическая форма, коматозное состояние в стадии декортикации.
Лабораторийн шинжилгээ (эмгэг судлалын материалд)	Ирүүлээгүй

БНХАУ-ын Баяннуур аймагт Шувууны томуугийн А хүрээний H7N9 вируст халдварын хүний өвчлөлийн тохиолдлын МЭДЭЭЛЭЛ

- ӨМӨЗО-ны Баяннуур аймгийн “Ганц мод” хилийн боомт орчимд шувууны томуугийн А(H7N9) вирусын хүний өвчлөлийн тохиолдол гарсан тухай МХЕГ-аас мэдээ ирүүлсэн(2017.06.01).
- Гашуун сухайт  Ганц мод
 - ӨМ-300 км (нүүрсний тээвэр)
 - УБ-600 км

Өмнөговь аймгийн ЗӨСТ-рүү бэлэн байдалыг хангаж ажиллах талаар үүрэг өгч ажиллаж байна.
- ХӨСҮТ, Өмнөговь аймгийн ЗӨСТ-тэй - Хамтарсан эрсдлийн үнэлгээ хийх

ДАЭМБ-ЫН МЭДЭЭ

Холер өвчний дэгдэлт: Йемен улс

Эх сурвалж	http://www.promedmail.org/
Хугацаа	2017.05.29
Хаана	Йемен улс
Өртсөн тоо	Тус улсад 2017.04.27-оос хойш 5 сарын 24-ны хугацаанд 42207 сэжигтэй тохиолдол, 420 нас баралт бүртгэгдээд байна.
Хариу арга хэмжээ	ДЭМБ нь тус улсын далайн боомтын Аден хотруу 22 тн холерийн оношлогооны тест, инсулин, сүрьеэ, суулгалтын эсрэг эм бэлдмэлүүдийг хүргүүлээд байна гэж мэдээллээ.




Корона вирус халдвар (MERS-Cov): Катар улс

Эх сурвалж	http://www.promedmail.org/
Хугацаа	2017.05.29
Хаана	Катар улс
Өртсөн тоо	<p>Катарын нийгмийн эрүүл мэндийн яамаас (MORH) Ойрхи Дорнодын амьсгалын замын хам шинж Корона вирус халдварын (MERS-Cov) батлагдсан нэг тохиолдлыг мэдээлсэн.</p> <p>Уг тохиолдол нь 29 настай, эрэгтэй, тэмээний фермийн ажилтан ба сүүлийн хэд хоногийн турш халуурах, хуурай ханиалгах шинж тэмдэг илэрсэн байна.</p>



Шувууны томуугийн H7N9 вируст халдвар: БНХАУ

Эх сурвалж	http://www.promedmail.org/
Хугацаа	2017.05.27
Хаана	Hubei, Shanxi, Sichuan,
Өртсөн тоо	БНХАУ-ын Hubei[27.05.2017], Shanxi[24.05.2017], Sichuan[24.05.2017] мужуудад шувууны томуугийн H7N9 вируст халдварын хүний өвчлөлийн тус бүр нэг тохиолдол нэмэгдэж бүртгэгдээд байна.
Хариу арга хэмжээ	<ul style="list-style-type: none">■ Халдваргүйтгэлийн арга хэмжээ■ Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа



Зика вирус халдвар: Энэтхэг улс

Эх сурвалж	Эх сурвалж: www.who.int
Хугацаа	2017.05.15
Хаана	Энэтхэг
Өртсөн тоо	Энэтхэг улсын гэр бүл халамж, эрүүл мэндийн яамнаас Зика вирус халварын лабораториор баталгаажсан 3 тохиолдол бүртгэгдсэнийг мэдээлсэн байна.
Хариу арга хэмжээ	<p>ДЭМБ-ийн эрсдэлийн үнэлгээ</p> <ul style="list-style-type: none">▪ Зика вирус халдварлалт бага түвшинд байгаа боловч цаашид шинэ тохиолдолууд нэмэгдэж болохыг анхааруулсан байна.▪ Эрсдэлийн үеийн харилцаа холбоог эрчимжүүлэн ажиллах



ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ: ЭРСДЭЛИЙН ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАА ХОЛБОО

ЭРСДЭЛИЙН ҮЕИЙН ХАРИЛЦАА ХОЛБОО

- Сэлэнгэ, Булган, Орхон, Дархан-Уул, Хөвсгөл, Хэнтий, Архангай зэрэг аймгууд болон ХӨСҮТ-тэй Хачгаар дамжих халдварт өвчний зайн сургалт 2017.06.06-ний өдөр зохион байгуулхаар бэлтгэл ажил хангагдаж байна.

ЭРСДЭЛИЙН ҮЕИЙН ХАРИЛЦАА ХОЛБОО

ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЬЕ!

ШУВУУНЫ ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХҮНСЭНД ХЭРЭГЛЭХ ЗӨВЛӨМЖ

Шувууны томуугийн вирус (АН7N9)-аар халдварласан шувууны мах, өндөг зэрэг бүтээгдэхүүн халдварын эрсдэлийг байнга дагуулж байдаг.

Шувууны томуугаар өвчлөмтгий ан агнуурын холбогдолтой зэрлэг шувууг агнаж, хоол хүнсэндээ хэрэглэхгүй байх.

Амьд шувуутай харьцах, шувуу нядлах болон шувууны гаралтай бүтээгдэхүүн (мах, өндөг)-тэй харьцсаны дараа гараа заавал бүлээн усаар сайтар савандаж угаах.

Шувууны гаралтай бүтээгдэхүүнийг худалдаж авахдаа аль улсад үйлдвэрлэсэн болохыг сайтар нягталж байх, Өвчлөл бүртгэгдсэн бүс нутгаас ирсэн бүтээгдэхүүнийг худалдан авахгүй байх

Шувууны гаралтай мах, махан бүтээгдэхүүн, өндгийг түүхий болон хагас боловсруулсан байдлаар хүнсэнд хэрэглэхгүй байх, Шувууны гаралтай мах, махан бүтээгдэхүүн, өндгийг халууны боловсруулалт хийсний дараа хүнсэндээ хэрэглэх

Зоонозын өвчин судлалын үндэсний төв

70282853
nczd.gov.mn
Зоонозын өвчин судлалын үндэсний төв

Хачгийн хөгжлийн мөчлөг

Хачиг нь 2-6 жилийн настай бөгөөд өндөг, авгалдай, нимф, бие гүйцсэн хачиг гэсэн 4 хөгжлийн үе шаттай



Хачгаар дамжих халдвар

Монгол оронд 9 өвч, 18 төрөл, 43 зүйлийн хачиг байдаг.

Ixodes	Dermacentor
Өвчлөл: Хачигт энцефалит Хачигт боррелиоз	Өвчлөл: Хачигт риккетсиоз Ку хазуурал
Өргөмтгий бие: 30-40 насны хүмүүс	Өргөмтгий 0-9 насны хүүхдүүд Бие:
Тархалт: Хусан ой мод бүхий нутаг	Тархалт: Нийт нутаг
Уиралчлал: IV-VIII сар	Уиралчлал: III-VIII сар

ЭМНЭЛЗҮЙН ШИНЖ ТЭМДЭГ

Ерөнхий шинж:

- Толой өвчлөх
- Хазуурах
- Үе мөч, бүлээн өвчлөх
- Тууралт гарах
- Яарих

Хачигт риккетсиоз өвчний онцлог шинж:

- Хачиг хачигт 2-3 см бүхий алслагч урвал үүсэх
- Туулайны бүлээн үүсэх
- Бүх биеэр тууралт гарах

Хачигт боррелиоз өвчний онцлог шинж:

- Хачиг хачигт 5 см дэвтэрч тууралт гарах
- Томооны үеэс урвалс би гол төвөгтэй үе үе эмнэх
- Захын мэдрэл урвалс

Хачигт энцефалит өвчний онцлог шинж:

- Хүрүү хонилс
- Үе мөч, тууруу, бүлээн өвчлөх
- Воволах
- Уялт сав саалт, мөнгөнцрийн шинж үүсэх

Хэрэв та хачигт хазуулснаас хойш **1-14** хоногийн дараа дээрх шинж тэмдэг илэрвэл эмнэлэгт яаралттай хандварай **III**

Зоонозын өвчин судлалын үндэсний төв

Утас: 70282853
 Цахим хаяг: www.nczd.gov.mn
 Цахим шуудан: nczd@nczd.gov.mn
 Цахим сайт: www.facebook.com/Зоонозын-Өвчин-Судлалын-Үндэсний-Төв

Шувууны гаралтай бүтээгдэхүүнийг хүнсэнд хэрэглэх зөвлөмж

Хачгаар дамжих халдварт өвчний цуврал 4 инфографик

МЭДЭЭНИЙ ХАНДАЛТ




Фэйсбүүк хуудсанд

- 4127 хүн хандсан.
- 5 хуваалцсан



Байгууллагын цахим хуудсанд

- 332 хүн хандсан



НИЙТ: ХҮН ХАНДСАН



**ШУУРХАЙ
УДИРДЛАГЫН
НЭГЖ**

**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**